

## ДОМЭЙН НЭР БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

### Нийтлэг үндэслэл

1. **ХҮСЭЛТ.** MN домэйн нэр бүртгэх үйлчилгээ нь бүгдэд нээлттэй бөгөөд бүртгүүлэгч бүр тэгш эрхтэйгээр, эхэлж ирсэн нь эхэлж бүртгүүлэх зарчмаар явагдана.
2. **ДОМЭЙН НЭРИЙН СОНГОЛТ.** Бүртгүүлэгч нь Датакомын домэйн нэр бүртгэлийн гэрээ, журамд дурдагдсан бүх нөхцлүүд, гуравдагч талын хууль ёсны эрх болон Датакомын Зөвшөөрөгдөх ашиглалтын журмыг зөрчихгүйгээр домэйн нэрээ хуулийн хүрээнд ашиглахыг хүлээн зөвшөөрнө.
3. **ЖУРАМ.** Домэйн нэр бүртгэх, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, дамжуулах, шилжүүлэх болон домэйн нэрийн маргаантай холбогдох үйлдлүүд нь .MN домэйн нэр бүртгэгч, ICANN (Internet Corporation for Assigned Names and Numbers), Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, журмын хүрээнд хийгдэнэ.
4. **ДОМЭЙН НЭР.** Бүртгэгч нь домэйн нэрийг идэвхтэй (домэйн нэрийн төлөөлөлтэй), идэвхгүй (нөөцлөгдсөн) гэсэн хоёр төлвөөр бүртгэнэ.

### Домэйн нэр бүртгүүлэгчийн мэдээлэл

5. **МЭДЭЭЛЭЛ.** Бүртгэгч нь Бүртгүүлэгчийн мэдээлэлийн үнэн зөв эсэхэд итгэлтэй байх үүднээс бүртгүүлэгчийн мэдээлсэн хууль ёсны хаягаар нь бүртгэнэ. Бүртгэлийн явцад Бүртгүүлэгч Бүртгэгчид тодорхой мэдээлэл өгөх болон ямар нэгэн өөрчлөлтийг мэдэгдэнэ. Бүртгүүлэгч нь (шууд эсвэл бүртгэгчээр дамжуулан) дараах мэдээллийг үнэн зөв бүртгүүлэх үүрэгтэй:
  - a. Бүртгүүлэгчийг төлөөлөх хүний хууль ёсны овог, нэр. (төлөөлөх хүн бүртгүүлэгч өөрөө байж болно);
  - b. Бүртгүүлэгч байгууллагын албан ёсны нэр (тухайн байгууллагыг хуулийн дагуу төлөөлөх эрхтэй этгээд домэйн нэр бүртгүүлэх хүсэлтийг гаргана)
  - c. Бүртгүүлэгчийн хүчинтэй шуудангийн хаяг;
  - d. Бүртгүүлэгчийн албан ёсны имэйл хаяг;
  - e. Бүртгүүлэгчийн албан ёсны утас, факсын дугаар (улсын код, бүсийн код, тохирох өргөтгөлийг агуулах ёстой)
6. Бүртгүүлэгч нь үйлчилгээний явцад дээрх мэдээллүүдэд орсон өөрчлөлтүүдийг Бүртгэгчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй. Хэрэв бүртгэгч нь бүртгүүлэгчийн мэдээлэл худал эсвэл алдаатай байх нөхцөлд бүртгүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүй тухайн домэйн нэрийг бүртгэхээс татгалзах, түдгэлзүүлэх, цуцлах эрхтэй ба энэ нөхцөлд бүртгэлийн төлбөрийг буцаан олгохгүй.
7. **БҮРТГЭЛИЙН НӨХЦӨЛ.** Бүртгүүлэгч домэйн нэрийн бүртгэлийн дараах зургаан нөхцөлтэй танилцан, хүлээн зөвшөөрсөн байна.
  - a. Домэйн нэр бүртгүүлэгч нь 1) МУ-н хуулиар зөвшөөрөгдсөн хуулийн этгээд (ТББ, Төр захиргааны байгууллага, ХХК, ХК, нөхөрлөл, хоршоо гэх мэт, Гадаадын хөрөнгө оруулалттай компани бол МУ-д үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх) эсвэл 2) 18 нас хүрсэн МУ-н иргэн байна (Гадаадын харъяат иргэн бол МУ-ын иргэн болсон байна);
  - b. Бүртгүүлэгч нь домэйн нэр бүртгэлийн энэхүү журмыг хүлээн зөвшөөрнө;
  - c. Домэйн нэр эзэмшигч нь хувийн мэдээллээ нууцлалын бодлогын хүрээнд интернэт дэх олон нийтэд нээлттэй WHOIS мэдээллийн санд байрлуулахыг зөвшөөрнө. Нээлттэй болгох зорилго нь зөвхөн Интернет домэйн нэрийн системтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оршино;
  - d. Бүртгүүлэгч нь домэйн нэр бүртгүүлэх хүсэлт гаргахдаа тухайн домэйн нэрийг дараах нөхцлийг зөрчихгүйгээр ашиглахыг зөвшөөрнө:
    - Аливаа гуравдагч этгээдийн хууль ёсны эрхэд ямар нэг байдлаар халдахгүй байх;
    - Тухайн домэйн нэрийг ашиглан ашиг хонжоо олох зорилгоор хэн нэгэн гуравдагч этгээдийн бараа, ажил үйлчилгээний тэмдэгтэй адилтгах, хууль бусаар ашиглан хэрэглэгчдийг төөрөгдүүлэхгүй байх;
    - Домэйн нэрийг ашиглах явцдаа санаатай болон санаандгүй байдлаар хууль, дүрэм, журам зөрчихгүй байх. Тухайн домэйн нэрийг бүртгүүлэх, ашиглахдаа хэн нэгэн гуравдагч этгээдийн эрх болон хууль зөрчөөгүй эсэхийг бүртгүүлэгч нь өөрөө шалгах үүрэгтэй.
    - Домэйн нэрийг садар самууныг сурталчлах зорилгоор ашиглахгүй байх;

е. Бүртгүүлэгч нь Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой гомдол болон зөрчил маргааныг шийдвэрлэхэд энэхүү журам болон ICANN-ийн холбогдох зөвлөмжийг үндэслэн ICANN-аас зөвшөөрсөн арбитр, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөх;

ф. Домэйн нэрийн бүртгэлийн төлбөрийг бүртгэгчид хугацаанд нь бүрэн төлсөн байх;

8. **ХОРИГЛОСОН МЭДЭЭЛЭЛ.** .MN домэйн нэрийн Зөвшөөрөгдөх ашиглалтын журмыг бүх бүртгүүлэгчид уншиж, танилцах үүрэгтэй. Энэхүү журмаар насанд хүрэгчдэд зориулсан мэдээллийг тусгайлан хориглодог. Тодруулбал:

- Шууд болон шууд бусаар үүсгэсэн холбоосыг ашиглан харилцах, үзүүлэх, холбох эсвэл түгээх үйл ажиллагааг Монгол Улсын хуулиар хориглосон эсвэл зөрчил гэж тодорхойлогдсон зураг, мэдээ мэдээллийг болон материалыг вэб сайт, электрон шуудан, мэдээний бүлэгт нийтлэх, интернэт хэлэлцүүлэг, мессеж, зурвас бичих зэрэг .mn Домэйн нэрийн үйлчилгээнд холбогдох зүйлст шууд эсвэл шууд бусаар холбон, байршуулж ашиглахыг;
- Нийгмийн тодорхой хэсгийн эсрэг хүүхдийг садар самуунд уруу татах, бэлгийн дур хүслийг ёс бусаар хангах, хүчирхийлэл эсвэл садар самууныг сурталчилсан зүйлс, бэлгийн харьцаа, түүнчлэн гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэхийг зааварчилсан материал, хориотой эм бэлдмэл бэлтгэх ашиглахыг заасан заавар зөвлөмж зэрэг Монголын улсын хуулиар хориглосон мэдээ мэдээлэл, материал зэргийг ойлгоно.

### **Бүртгэлийн хугацаа**

9. **ХУГАЦАА.** Тухайн домэйн нэрийн хувьд үйлчилгээ болон энэхүү журмын хүчинтэй үйлчлэх хугацаа нь бүртгүүлэгчийн өөрөө сонгож, төлбөр төлсөн хугацаагаар тодорхойлогдоно. Хүчинтэй хугацаа дуусахад бүртгүүлэгч нь сунгалтын төлбөр төлж үйлчилгээний хугацааг сунгасан бол энэхүү журам, гэрээний үйлчлэх хугацаа түүнтэй тэнцэх хугацаагаар сунгагдсанд тооцно. Бүртгүүлэгч нь домэйн нэрээ бусдад шилжүүлсэн бол тухайн бүртгүүлэгчийн хувьд энэхүү журмын үйлчлэх хугацаа дуусгавар болно.
10. Бүх домэйн нэр тодорхой хугацаатай бүртгэгдэнэ. Бүртгүүлэгч нь хууль зүйн үүднээс ямар нэг асуудал гараагүй бол домэйн нэрийн сунгалтын төлбөрийг домэйн нэрийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө төлж сунгах үүрэгтэй. Бүртгүүлэгч нь домэйн нэрийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө хугацаанд нь төлбөрөө төлөөгүй тохиолдолд тухайн Бүртгүүлэгчийн зүгээс уг домэйн нэрийг өөр бүртгүүлэгч бүртгүүлэхийг бүрэн хүлээн зөвшөөрнө. Бүртгүүлэгч нь хүчинтэй хугацаа дуусаж, сунгах тухай мэдэгдэл хүлээн аваагүй нь уг домэйн нэрийг үргэлжлүүлэн сунгаж эзэмших үндэслэл болохгүй.

### **Домэйн нэрийг сонгох**

11. Домэйн нэр нь A-Z, a-z англи цагаан толгойн үсэг, 0-9 тоо болон зураас (" ") тэмдэгтүүдээс бүртсэн 3-63 тэмдэгийн урттай байна. Нэрийн хамгийн эхний ба сүүлийн тэмдэгт нь үсэг эсвэл тоо байх ёстой. Нэгэнт сонгож, бүртгүүлсэн домэйн нэрийг өөрчлөх боломжгүй ба энэ нөхцөлд домэйн нэрийг шинээр сонгож, төлбөрийг хийж, бүртгүүлнэ.
12. Эхэлж төлбөрөө төлсөн бүртгүүлэгч эхэлж үйлчлүүлнэ.

### **Төлбөрийн журам, төлбөр тооцоо**

13. **ТӨЛБӨР.** Бүртгүүлэгч нь домэйн нэр ашиглах үйлчилгээний төлбөрийг бүртгэгч, эсвэл Ресэллэрт (үүнийг итгэмжлэгдсэн бүртгэгч гэнэ) төлнө. Үйлчилгээний төлбөрийг үйлчилгээг эхлэхээс өмнө урьдчилан төлөх ба ямар ч тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй.
14. **ҮНЭ.** Домэйн нэр ашиглах үйлчилгээний төлбөрийг 1-10 жилээр тооцох ба нэг (1) жилийн үйлчилгээний хураамж 45000 төгрөг (НӨАТ нэмэгдэнэ) байна. Устсан домэйн нэрийг дахин сэргээж, хугацааг сунгахад домэйн нэрийн жилийн сунгалтын төлбөрөөс гадна сэргээлтийн төлбөр 137245 төгрөг (НӨАТ нэмэгдэнэ)-ийг төлнө. Сэргээгдэх хугацаа нь уг домэйн нэр устсанаас хойш 30 хоногийн хугацаанд /Redemption Period/ байна.
15. Бүртгүүлэгч нь домэйн нэр бүртгэлийн энэхүү журамд заасны дагуу бүх төлбөр тооцоог хугацаанд нь барагдуулна. Бүртгэгч болон итгэмжлэгдсэн бүртгэгч нь бүртгүүлэгчийн мэдээлэл хуучин, буруу эсвэл шуудан болон электрон шуудан дамжуулагчдын буруугаас электрон шуудан, илгээмж очоогүйн хариуцлагыг хүлээхгүй. Иймээс Бүртгүүлэгч нь мэдээллийн өөрчлөлтөө цаг тухайд нь онлайнаар, имэйлээр болон бичгэн хэлбэрээр мэдээлэх үүрэгтэй. Бүртгүүлэгч нь хаягийн өөрчлөлт болон төлбөр

тооцоотой холбоотой асуудлыг Бүртгэгч болон итгэмжлэгдсэн бүртгэгчийн и-мэйл хаягаар цаг алдалгүй илгээх үүрэгтэй.

### Маргаан шийдвэрлэх журам

16. Бүртгэгчийн бүртгэсэн домэйн нэрийг ашиглах талаар ямар нэг маргаан гарвал үүнийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх ба бүртгэгч нь аль нэг талд зөвлөхгүй. Тухайн домэйн нэрийн хувьд түүнийг ашиглах эрхийн талаар гарсан аливаа маргаанд бүртгэгчийн зүгээс оролцохгүй ба талуудад WHOIS мэдээллийн сан дахь мэдээллээр хангахаас өөр үүргийг хүлээхгүй.

Хэрэв домэйн нэр бүртгүүлэгч домэйн нэрийг зохих ёсны дагуу ашиглаагүй мөн буруугаар болон таны эрх ашгийг ямар нэгэн байдлаар зөрчиж байгаа бол энэ талаар Бүртгүүлэгчид шууд хандаж болно. Бүртгэгч нь Whois мэдээллийн санд дахь бүртгүүлэгчийн мэдээллийг танд вэб сайтаар дамжуулан хүргэнэ.

Бүртгэгч нь ICANN-ийн UDRP (Uniform Domain Name Dispute Resolution Policy/ Домэйн нэр ашиглах эрхийн маргаан шийдвэрлэх журам)ыг мөрдлөг болгож мөн энэхүү журамд заасны дагуу уг маргааныг эрх бүхий гуравдагч этгээд шийдвэрлэхийг зөвшөөрнө. “Домэйн нэр ашиглах эрхийн маргаан шийдвэрлэх журам” ын 6 болон 7 дахь хэсэгт бүртгүүлэгч болон гуравдагч этгээдийн хоорондын маргаанд бүртгэгч оролцохгүй болохыг тодорхой заасан.

### Спам

17. Бүртгэгч нь аливаа домэйн нэрийг төрөл бүрийн зарлал, сурталчилгаа, мэдээллийн и-мэйлийг зөвшөөрөлгүй илгээх (spamming), хууль бус үйлдэлд ашигласан тухай мэдээллийг хүлээн авсан тохиолдолд уг домэйн нэрийг бүртгүүлэгчид энэ талаар сануулж, хууль бус үйлдлээ зогсоох талаар хүсэлт тавина. Аливаа домэйн нэрийг төрөл бүрийн зарлал, сурталчилгаа, мэдээллийн имэйлийг зөвшөөрөлгүй илгээх, хууль бус үйлдэлд ашигласан тохиолдолд бүртгэгч нь бүртгүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр, төлбөрийн буцаалт хийлгүйгээр уг домэйн нэрийг ашиглах эрхийг цуцлах, түдгэлзүүлэх эрхтэй.

### Домэйн нэр шилжүүлэх журам

18. Бүртгүүлэгч нь домэйн нэрийг шилжүүлэхэд холбогдох төлбөрийг бүртгэгчид бүрэн төлсөн байна. Домэйн нэрийг нэг бүртгэгчээс нөгөөд шилжүүлэхэд домэйн нэрийн хугацаа нэг жилээр сунгагдах ба шилжүүлэлт бүрт домэйн нэрийн бүртгүүлэгч нь бүртгэлийн нэг жилийн сунгалтын төлбөрийг шинээр хариуцаж буй бүртгэгчид төлж сунгуулна.

### Бусад

19. **ӨӨРЧЛӨЛТ.** Бүртгэгч нь Бүртгүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр .MN домэйн нэр бүртгэлийн журамд хэдийд ч нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд шинэчлэгдэн өөрчлөгдсөн журам нь вэбэд илгээгдсэн өдрөөс эхлэн хуанлын 5 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Бүртгүүлэгч нь домэйн нэр бүртгэх журмын өөрчлөлт, шинэчлэлтийг бүртгэгчийн www.datasom.mn вэб сайтаас тогтмол уншиж танилцах үүрэгтэй.
20. **ҮҮРГИЙН ХЯЗГААРЛАЛТ.** Домэйн нэрийг үйлчилгээг ашигласнаас болон ашиглаж чадаагүйн улмаас үүдэн гарах шууд, шууд бус, онцгой үр дагаварууд, хохирлын хувьд бүртгэгч ямар нэгэн байдлаар хуулийн хүрээнд хариуцахгүй.
21. **ЗӨРЧИЛ.** Бүртгүүлэгч нь домэйн нэр бүртгэх энэхүү журмыг зөрчсөн аливаа үйлдэлд бүртгэгч нь тухайн зөрчлийн талаар бүртгүүлэгчид албан ёсоор и-мэйлээр мэдэгдэл өгнө. Хэрэв талууд зөрчилтэй холбоотой асуудлыг хуанлын 5хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй бол бүртгэгч үйлчилгээг цуцлах эрхтэй.
22. **БАТАЛГАА БУС.** Бүртгүүлэгчийн сонгосон домэйн нэр нь нөөцлөгдсөн эсвэл өмнө нь бүртгэгдсэн байх нь өөр домэйн нэр бүртгүүлэн ашиглахаас татгалзах шалтгаан болохгүй.
23. **ЭРХ ХАДГАЛАГДАХ.** Бүртгэгч нь бүртгэлийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангах, холбогдох хууль, тогтоомж болон хуулийн хэрэгжилтийн шаардлага, болон маргаан, иргэн, эрүүгийн хэрэг шийдвэрлэхтэй холбогдсон шаардлагаар домэйн нэр бүртгэхээс татгалзах, бүртгэлийг цуцлах, шилжүүлж болно. Мөн бүртгэгч нь маргаан шийдэгдэх хугацаанд холбогдох домэйн нэрийн бүртгэлийг түдгэлзүүлэх эрхтэй.

24. **БАТАЛГААНЫ ҮГҮЙСГЭЛ.** Бүртгэгч нь домэйн нэрийн үйлчилгээг бүртгүүлэгчийн бүхий л шаардлагыг хангаж чадах болон үйлчилгээ ямар ч алдаа доголдолгүй, тасралтгүй ажиллах талаар ямар нэгэн баталгаа өгөхгүй.
25. **ХҮЧИНГҮЙ БОЛГОХ.** .MN домэйн нэр бүртгэх журам болон бүртгэлийн гэрээг зөрчсөн дараах 3 үйлдэл нь тухайн домэйн нэрийн бүртгэлийг цуцлах, зогсоох, хүчингүй болгох, буцаан авах хангалттай шалтгаан болохыг бүртгүүлэгч нь бүрэн хүлээн зөвшөөрнө. Үүнд:
- a. Аливаа хүний нэр хүндийг гутаах, доромжлох үйлдэл, үйл ажиллагаа;
  - b. Залилан мэхэлсэн болон хууль бус бусад үйлдэл, үйл ажиллагаа;
  - c. Оюуны өмчийн эрхийг зөрчсөн болон бусад гуравдагч талын эрхийг зөрчсөн үйлдэл, үйл ажиллагаа;
26. **МЭДЭГДЭЛ.** Гэрээтэй холбоотой ямар нэгэн мэдэгдэл, зөвлөмж болон бусад харилцаа нь бичгээр хийгдэж, электрон шуудан эсхүл ердийн шуудангаар илгээгдэнэ.
27. **УДИРДЛАГА БОЛГОХ ХУУЛЬ.** Энэхүү журам нь ICANN-ын стандарт, журамд захирагдана.
28. **ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ.** Бүртгүүлэгч нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр бүртгэгч энэхүү журмаар хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй болсон тохиолдолд ямар нэг хариуцлага хүлээхгүй.